

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалт

Огноо:	2016 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр
Төслийн дугаар, нэр:	L3072-MON: Төлбөрийн системийн шинэчлэл төсөл
Тендер шалгаруулалтын дугаар, нэр:	NETC/Goods /2016 -019: ҮЦГТ-ийн Сүлжээний үндсэн төхөөрөмжүүд болон сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах (Замчлагч, свитч, дараа үеийн хамгаалалт)
Тендерийн материал ирүүлэх сүүлийн хугацаа:	2016 оны оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 15:00 цагт

1. Монгол улсын Засгийн газар нь Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, энэхүү төслийн хүрээнд NETC/Goods /2016 -019 дугаартай Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн сүлжээний үндсэн төхөөрөмжүүд (Замчлагч, свитч, дараа үеийн галт хана)-ийг нийлүүлэх худалдан авах ажиллагааг санхүүжүүлнэ.
2. Монголбанк эрх бүхий тендерт оролцогчдоос Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн сүлжээний үндсэн төхөөрөмжүүд (Замчлагч, свитч, дараа үеийн галт хана)-ийг нийлүүлэх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
3. Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг АХБ-ны нэг шаттай, нэг дугтуйт горимын дагуу явуулах бөгөөд эрх бүхий орны харьяат нийт тендерт оролцогчдод нээлттэй байна.
4. Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь Төлбөрийн системийн шинэчлэл төслөөс нэмэлт мэдээлэл авах, Улаанбаатарын цагаар 09:00 – 17:00 цагийн хооронд урилгын төгсгөлд заасан хаягт хүрэлцэн ирж тендерийн баримт бичигтэй танилцах боломжтой.
5. Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, 50,000 (тавин мянган) төгрөгтэй тэнцэх хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгээр төлсөнөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн тендерийн баримт бичгийг худалдан авч болно. Төлбөрийг Төслийн нэгжийн Төрийн банкин дахь 109000067145 тоот дансанд шууд шилжүүлнэ. Баримт бичгийг ердийн шуудангаар дотоодод илгээх бөгөөд гадаад улсад илгээх тохиолдолд нэмэлт. 150,000 (нэг зуун тавин мянган) төгрөгөөр бухиа шуудангаар хүргүүлэх болно. Монголбанк нь баримт бичиг алга болох эсхүл хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотой ямар нэг хариуцлага хүлээхгүй.
6. Тендерийг 2016 оны оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 15:00 цагт эсхүл түүнээс өмнө урилгын төгсгөлд заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг 2016 оны оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 15:00 цагт доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.
*Хаяг: Монгол Улс, 15160, Улаанбаатар-46, Бага тойруу-3
Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн байрны хурлын танхим*
7. Тендер бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор тендерт оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Монголбанк хариуцахгүй.

Монголбанкны “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”

Хаяг: Монгол Улс, 15160, Улаанбаатар-46, Бага тойруу-3, Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн байр,

Утас: +976-70119910; Факс: 976-11-311471

И-мэйл: d.tuul@mongolbank.mn, procurement@psmp.mn

Худалдан авалтын мэргэжилтэн Д. Туул